



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 01 сарын 10 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.1.2.в, 11.1.2.г дэд заалт нэмсүгэй:

"11.1.2.в. Ашигт малтмалын тухай хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон Цөмийн энергийн тухай хуулийн 20¹.5-д заасан цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр;

11.1.2.г. Цөмийн энергийн тухай хуулийн 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх зэрэг хувилбараар орлуулснаас бий болсон татварын бус орлого."

2 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.а, 11.1.2.б дэд заалтын "уул уурхайн олборлолт" гэсний өмнө "энэ хуулийн 12.9-д заасны дагуу төвлөрүүлсэн ногдол ашгаас" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтын "Хуримтлалын сан энэ хуулийн 12.9-д заасны дагуу төвлөрүүлсэн ногдол ашгаас дараах зарчмаар хуваарилсан эх үүсвэрээс бүрдэнэ:" гэснийг "Хуримтлалын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН